iii) Pour l'application du a aux revenus visés au paragraphe 2 de l'article 10, au paragraphe 2 de l'article 11 et au paragraphe 2 de l'article 12, lorsque l'impôt mongol fait l'objet d'une réduction ou d'une exonération temporaires en application d'un régime d'incitation fiscale en vue de promouvoir le développement économique de la Mongolie, le montant de l'impôt payé en Mongolie est considéré comme étant égal à celui qui aurait dû être payé,

dans les limites fixées par la Convention, en vertu de la législation mongole de droit commun. Les dispositions du présent iii) s'appliquent pendant 10 ans à compter de la date de prise d'effet de la Convention. Cette période de 10 ans peut être prolongée d'un commun accord par les autorités compétentes des Etats contractants.

2. En ce qui concerne la Mongolie les doubles impositions sont éliminées de la manière suivante :

a) Lorsqu'un résident de la Mongolie reçoit des revenus de France, le montant de l'impôt dû en France sur ces revenus conformément aux dispositions de la Convention est déductible de l'impôt mongol dû par ce résident. Le montant de ce crédit ne peut toutefois excéder le montant de l'impôt mongol sur ces revenus, calculé conformément à la législation mongole.

b) Lorsque les revenus reçus de France sont des dividendes payés par une société qui est un résident de France à une société qui est un résident de la Mongolie et qui détient au moins 10 % du capital de la société qui paie les dividendes, le crédit tient compte de l'impôt payé par la première société au titre des bénéfices qui servent au paiement des dividendes.

Article 24. Non-discrimination

1. Les personnes physiques possédant la nationalité d'un Etat contractant ne sont soumises dans l'autre Etat contractant à aucune imposition ou obligation y relative, qui est autre ou plus lourde que celles auxquelles sont ou pourront être assujetties les personnes physiques possédant la nationalité de cet autre Etat qui se trouvent dans la même situation notamment au regard de la résidence.

2. L'imposition d'un établissement stable qu'une entreprise d'un Etat contractant a dans l'autre Etat contractant n'est pas établie dans cet autre Etat d'une façon moins favorable que l'imposition des entreprises de cet autre Etat qui exercent la même activité. La présente disposition ne peut être interprétée comme obligeant un Etat contractant à accorder aux résidents de l'autre Etat contractant les déductions personnelles, abattements et réductions d'impôt en fonction de la situation ou des charges de famille qu'il accorde à ses propres résidents.

3. A moins que les dispositions du paragraphe 1 de l'article 9, du paragraphe 7 de l'article 11 ou du paragraphe 7 de l'article 12 ne soient applicables, les intérêts, redevances et autres dépenses payés par une entreprise d'un Etat contractant à un résident de l'autre Etat contractant sont déductibles, pour la détermination des bénéfices imposables de cette entreprise, dans les mêmes conditions que s'ils avaient été payés à un résident du premier Etat. De même, les dettes d'une entreprise d'un Etat contractant envers un résident de l'autre Etat contractant sont déductibles, pour la détermination de la fortune imposable de cette entreprise, dans les mêmes conditions que si elles avaient été contractées envers un résident du premier Etat.

4. Les entreprises d'un Etat contractant, dont le capital est en totalité ou en partie, directement ou indirectement, détenu ou contrôlé par un ou plusieurs résidents de l'autre Etat contractant, ne sont soumises dans le premier Etat à aucune imposition ou obligation y relative, qui est autre ou plus lourde que celles auxquelles sont ou pourront être assujetties les autres entreprises similaires du premier Etat.

5. Sous réserve d'accord cas par cas entre les autorités compétentes, les exonérations d'impôt et autres avantages prévus par la législation fiscale d'un Etat contractant au profit de cet Etat, de ses subdivisions ou de ses collectivités locales, ou de leurs personnes morales de droit public dont l'activité n'a pas un caractère industriel ou commercial, s'appliquent dans les mêmes conditions respectivement à l'autre Etat contractant, à ses subdivisions ou à ses collectivités locales, ou à leurs personnes morales de droit public dont l'activité est identique ou analogue. Nonobstant les dispositions du paragraphe 6, les dispositions du présent paragraphe ne s'appliquent pas aux impôts ou taxes dus en contrepartie de services rendus.

6. Les dispositions du présent article s'appliquent, nonobstant les dispositions de l'article 2, aux impôts de toute nature ou dénomination.

7. Si un traité, accord ou convention entre les Etats contractants, autre que la présente Convention, comporte une clause de non-discrimination ou une clause de la nation la plus favorisée, il est entendu que de telles clauses ne sont pas applicables en matière fiscale.

Article 25. Procédure Amiable

1. Lorsqu'une personne estime que les mesures prises par un Etat contractant ou par les deux Etats contractants entraînent ou entraîneront pour elle une imposition non conforme aux dispositions de la présente Convention, elle peut, indépendamment des recours prévus par le droit interne de ces Etats, soumettre son cas à l'autorité compétente de l'Etat contractant dont elle est un résident ou, si son cas relève du paragraphe 1 de l'article 24, à celle de l'Etat contractant dont elle possède la nationalité. Le cas doit être soumis dans les trois ans qui suivent la première notification de la mesure qui entraîne une imposition non conforme aux dispositions de la Convention.

2. L'autorité compétente s'efforce, si la réclamation lui paraît fondée et si elle n'est pas elle-même en mesure d'y apporter une solution satisfaisante, de résoudre le cas par voie d'accord amiable avec l'autorité compétente de l'autre Etat contractant, en vue d'éviter une imposition non conforme à la Convention. L'accord est appliqué quels que soient les délais prévus par le droit interne des Etats contractants.

3. Les autorités compétentes des Etats contractants s'efforcent, par voie d'accord amiable, de résoudre les difficultés ou de dissiper les doutes auxquels peuvent donner lieu l'interprétation ou l'application de la Convention. Elles peuvent aussi se concerter en vue d'éliminer la double imposition dans les cas non prévus par la Convention.

4. Les autorités compétentes des Etats contractants peuvent communiquer directement entre elles en vue de parvenir à un accord comme il est indiqué aux paragraphes précédents. Si des échanges de vues oraux semblent devoir faciliter cet accord, ces échanges de vues peuvent avoir lieu au sein d'une commission composée de représentants des autorités compétentes des Etats contractants.

5. Les autorités compétentes des Etats contractants peuvent régler d'un commun accord les modalités d'application de la Convention et notamment les formalités que doivent accomplir les résidents d'un Etat contractant pour obtenir, dans l'autre Etat contractant, les avantages prévus par la Convention. Ces formalités peuvent comprendre la présentation d'un formulaire d'attestation de résidence indiquant en particulier la nature et le montant ou

la valeur des revenus ou de la fortune concernés, et comportant la certification des services fiscaux de cet autre Etat.

Article 26. Echange de Renseignements

1. Les autorités compétentes des Etats contractants échangent les renseignements nécessaires pour appliquer les dispositions de la présente Convention, ou celles de la législation interne des Etats contractants relative aux impôts visés par la Convention, dans la mesure où l'imposition qu'elle prévoit n'est pas contraire à la Convention. L'échange de renseignements n'est pas restreint par l'article 1. Les renseignements reçus par un Etat contractant sont tenus secrets de la même manière que les renseignements obtenus en application de la législation interne de cet Etat et ne sont communiqués qu'aux personnes ou autorités (y compris les tribunaux et organes administratifs) concernées par l'établissement ou le recouvrement des impôts visés par la Convention, par les procédures ou poursuites concernant ces impôts, ou par les décisions sur les recours relatifs à ces impôts. Ces personnes ou autorités n'utilisent ces renseignements qu'à ces fins. Elles peuvent faire état de ces renseignements au cours d'audiences publiques de tribunaux ou dans des jugements.

2. Les dispositions du paragraphe 1 ne peuvent en aucun cas être interprétées comme imposant à un Etat contractant l'obligation :

a) De prendre des mesures administratives dérogeant à sa législation et à sa pratique administrative ou à celles de l'autre Etat contractant ;

b) De fournir des renseignements qui ne pourraient être obtenus sur la base de sa législation ou dans le cadre de sa pratique administrative normale ou de celles de l'autre Etat contractant ;

c) De fournir des renseignements qui révéleraient un secret commercial, industriel, professionnel ou un procédé commercial ou des renseignements dont la communication serait contraire à l'ordre public.

Article 27. Fonctionnaires Diplomatiques et Consulaires

Les dispositions de la présente Convention ne portent pas atteinte aux privilèges fiscaux dont bénéficient les membres des missions diplomatiques et leurs domestiques privés, les membres des postes consulaires, et les membres des délégations permanentes auprès d'organisations internationales en vertu soit des règles générales du droit international soit des dispositions d'accords particuliers.

Article 28. Entrée en Vigueur

1. Chacun des Etats contractants notifiera à l'autre l'accomplissement des procédures requises en ce qui le concerne pour la mise en vigueur de la présente Convention. Celle-ci entrera en vigueur le premier jour du deuxième mois suivant le jour de réception de la dernière de ces notifications.

2. Les dispositions de la Convention s'appliqueront :

a) En ce qui concerne les impôts sur le revenu, aux revenus afférents à toute année civile ou exercice comptable commençant après l'année civile au cours de laquelle la Convention est entrée en vigueur ;

b) En ce qui concerne les autres impôts, aux impositions dont le fait générateur interviendra après l'année civile au cours de laquelle la Convention est entrée en vigueur.

Article 29. Dénonciation

1. La présente Convention demeurera en vigueur sans limitation de durée. Toutefois, après la cinquième année civile suivant la date d'entrée en vigueur de la Convention, chacun des Etats contractants pourra, moyennant un préavis minimum de six mois notifié par la voie diplomatique, la dénoncer pour la fin d'une année civile.

2. Dans ce cas, la Convention ne sera plus applicable :

a) En ce qui concerne les impôts sur le revenu, aux revenus afférents à toute année civile ou exercice comptable commençant après l'année civile au cours de laquelle la dénonciation aura été notifiée ;

b) En ce qui concerne les autres impôts, aux impositions dont le fait générateur interviendra après l'année civile au cours de laquelle la dénonciation aura été notifiée.

En foi de quoi les soussignés, dûment autorisés à cet effet, ont signé la présente Convention.

Fait à Paris le 18 avril 1996, en double exemplaire, en langues française et mongole, les deux textes faisant également foi.

Pour le Gouvernement de la République française :

JACQUES TOUBON

Pour le Gouvernement de la Mongolie :

T. TJOGT

Ministre du Commerce et de l'Industrie

PROTOCOLE

Au moment de procéder à la signature de la Convention entre le Gouvernement de la République française et le Gouvernement de la Mongolie en vue d'éviter les doubles impositions et de prévenir l'évasion et la fraude fiscales en matière d'impôts sur le revenu et sur la fortune, les soussignés sont convenus des dispositions suivantes qui font partie intégrante de la Convention.

1. En ce qui concerne l'article 2, la taxe sur les salaires visée au a du paragraphe 3 est régie par les dispositions de la Convention applicables, suivant les cas, aux bénéfices des entreprises ou aux revenus des professions indépendantes.

2. En ce qui concerne l'article 7, il est entendu que :

a) Lorsqu'une entreprise d'un Etat contractant vend des marchandises ou exerce une activité dans l'autre Etat contractant par l'intermédiaire d'un établissement stable qui y est situé, les bénéfices de cet établissement stable ne sont pas calculés sur la base du montant total reçu par l'entreprise mais sur la seule base de la rémunération imputable à l'activité réelle de l'établissement stable pour ces ventes ou pour cette activité ;

b) Dans le cas de contrats, s'agissant notamment de contrats d'étude, de fourniture, d'installation ou de construction d'équipements ou d'établissements industriels, commerciaux ou scientifiques, ou d'ouvrages publics, lorsque l'entreprise a un établissement stable, les bénéfices de cet établissement stable ne sont pas déterminés sur la base du montant total du contrat, mais seulement sur la base de la part du contrat qui est effectivement exécutée par cet établissement stable dans l'Etat contractant où il est situé. Les bénéfices afférents à la part du contrat qui est exécutée dans l'Etat contractant où est situé le siège de direction effective de l'entreprise ne sont imposables que dans cet Etat.

3. En ce qui concerne l'article 8, si l'un des Etats contractants estime souhaitable d'étendre les dispositions de cet article au transport ferroviaire, les Etats contractants engageront des discussions en vue d'examiner la possibilité d'une telle extension.

4. En ce qui concerne l'article 12, les rémunérations payées pour des services techniques, y compris des analyses ou des études de nature scientifique, géologique ou technique, pour des travaux d'ingénierie y compris les plans y afférents, ou pour des services de consultation ou de surveillance, ne sont pas considérées comme des rémunérations payées pour des informations ayant trait à une expérience acquise dans le domaine industriel, commercial ou scientifique, mais comme des revenus auxquels s'appliquent, suivant les cas, les dispositions de l'article 7 ou de l'article 14.

5. Si, conformément à sa législation interne, la France détermine les bénéfices imposables de résidents de France en déduisant les déficits de filiales qui sont des résidents de la Mongolie ou d'établissements stables situés en Mongolie, et en intégrant les bénéfices de ces filiales ou de ces établissements stables à concurrence du montant des déficits déduits, les dispositions de la Convention ne s'opposent pas à l'application de cette législation.

6. Les dispositions de la Convention n'empêchent en rien la France d'appliquer les dispositions des articles 209 B, 209 quinquies et 212 de son code général des impôts ou d'autres dispositions analogues qui amenderaient ou remplaceraient celles de ces articles.

En foi de quoi les soussignés, dûment autorisés à cet effet, ont signé le présent protocole.

Fait à Paris le 18 avril 1996, en double exemplaire, en langues française et mongole, les deux textes faisant également foi

Pour le Gouvernement de la République française :

JACQUES TOUBON

Pour le Gouvernement de la Mongolie :

T. TJOGT

[MONGOLIAN TEXT — TEXTE MONGOL]

**ОРЛОГО БА ХӨРӨНГИЙН ТАТВАРЫГ ДАВХАРДУУЛЖ
НОГДУУЛАХГҮЙ БАЙХ. ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХ
ЯВДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ
ФРАНЦ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗАР ХООРОНДЫН КОНВЕНЦ**

Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Конвенц байгуулахаар шийдвэрлэж, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар дараах зүйлийг хэлэлцэн тохиров:

1 дүгээр зүйл. Хамаарагдах этгээл

Энэхүү Конвенц нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу эдгээрийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдийг хамаарна.

2 дугаар зүйл. Хамаарагдах татварууд

1. Хэлэлцэн тохирогч Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн нэрийн өмнөөс орлогод ба хөрөнгөд ногдуулж буй татварууд нь тэдгээрийг хэрхэн ногдуулж байгаа хэлбэрээс үл шалтгаалан энэхүү Конвенцид хамаарна.

2. Орлого ба хөрөнгөд ногдуулж буй татвар гэж нийт орлого буюу нийт хөрөнгө болон орлого буюу хөрөнгийн бүрэлдхүүн хэсэгт ногдуулж буй бүх төрлийн татвар, түүний дотор хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийн борлуулалтын орлого, аж ахуйн нэгжийн цалин хөлсний нийт хэмжээ болон хөрөнгийн үнэлгээний өсөлтийн орлогод ногдуулах татварыг хэлнэ.

3. Конвенцид одоо мөрдөгдөж байгаа дараах татварууд хамаарагдана. Тухайлбал:

а/ Бүгд Найрамдах Франц Улсын хувьд:

- аа/ орлогын татвар.
- бб/ компаний татвар.
- вв/ цалингийн татвар.
- гг/ хөрөнгийн татвар.

/ Цаашид “Францын татвар” гэнэ /

б/ Монгол Улсын хувьд:

- аа/ хүн амын орлогын албан татвар.
- бб/ аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар.

/ цаашид “Монголын татвар” гэнэ /

4. Энэхүү Конвенцид гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр бий болсон, одоогийн татварт нэмэлт болох буюу тэлгээрийг орлох татварууд

нь дээр дурдсан татваруудтай адил буюу төстэй байвал энэхүү Конвенцид мөн хамаарагдана. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллага нь өөрийн орны татварын хуульд орсон аливаа зарчмын өөрчлөлтний талаар нөгөө талдаа мэдэгдэж байна.

3 дугаар зүйл. Ерөнхий тодорхойлолт

1. Энэхүү Конвенцид нөхцөл байдал өөрөөр тайлбар хийхийг шаардаагүй бол:

а/ “Хэлэлцэн тохирогч Улс” болон “Хэлэлцэн тохирогч нөгөө Улс” гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол болон Францыг хэлнэ,

б/ “Монгол” гэж Монгол Улс, газар зүйн утгаараа авч үзвэл Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ,

в/ “засаг захиргааны нэгж” гэж Монгол Улсын засаг захиргааны нэгжийг хэлнэ,

г/ “Франц” гэж Бүгд Найрамдах Франц Улсын Европын болон далайн чанад дахь департаментууд, түүний газар нутгийн далай тэвгис түүнээс цаашир, тухайлбал Бүгд Найрамдах Франц Улс олон улсын эрх зүйн дагуу байгалийн баялгийг нь хайх, олборлон ашиглах эрх бүхий далайн ёроол, түүний хэвлий, гадаргууны усыг хэлнэ.

д/ “этгээд” гэж хувь хүн, компани болон бусад бүлэг этгээдийг хэлнэ,

е/ “компани” гэж хуулийн эрх бүхий аливаа этгээд буюу татвар ногдуулах утгаараа түүнтэй адилтгах аливаа байгууллагыг хэлнэ,

ж/ “Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж” гэж тухайн энэ Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ. “Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж” гэж тухайн нөгөө Улсад байнга оршин суугч этгээдийн эрхэлдэг аж ахуйн нэгжийг хэлнэ,

з/ “олон улсын тээвэр” гэж Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад голлох удирдлага нь байрладаг аж ахуйн нэгжээс хөлөг онгоц болон нисэх онгоцоор хийх аливаа тээврийн үйл ажиллагааг хэлэх бөгөөд харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс доторхи байрлалуудын хооронд хөлөг онгоц болон нисэх онгоцоор хийх тээврийн үйл ажиллагааг үүнд үл хамаарна,

и/ “эрх бүхий этгээд” гэж:

1/ Бүгд Найрамдах Франц Улсын хувьд Төсвийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгч, болон

2/ Монгол Улсын хувьд Сапгийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2. Энэхүү Конвенцид тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Конвенцнор зохицуулагдаж буй татвартай холбогдол бүхий Хэлэлцэн

тохирогч Улсын дотоодын хуульд зааснаар ойлгоно. Хэлэлцэн тохирогч Улсын дотоодын хууль гэж энэ тохнолдолд тухайн Улсын хуулиуд дотроос голлон татварын хуулийг хэлнэ.

4 дүгээр зүйл. Байнга оршин суугч

1. Энэхүү Конвенцад “Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч” гэж өөрөө болон голлох удирдлага нь байнга оршин сууж, байрлаж байгаа, мөн үүнтэй адилтгах бусад шалтгаанаар оршин сууж, байрлаж тэр Улсын хуулийн дагуу тухайн Улсад татвар төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Гэвч энэ нь тухайн Улс дахь эх үүсвэрээс орлого олсон ба тэнд оршдог хөрөнгөөс олсон орлогоосоо тухайн Улсад татвар төлөх ёстой аливаа этгээдийг хамрахгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч хувь этгээдийн статусыг дараахь байдлаар тодорхойлно:

а/ байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа (язгуур эрх ашгийн төв) нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно.

б/ хэрэв түүний язгуур эрх ашгийн төв бүхий Улсыг тодорхойлох аргагүй, эсвэл энэ хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр улсын байнга оршин суугч гэж тооцно.

в/ хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь түр орогнох байртай, эсвэл алинд нь ч байхгүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харьяат байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно.

г/ хэрэв хувь этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины харьяат эсвэл алиных нь ч харьяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд харьцан зөвшөөрөлцсөнөөр шийдвэрлэнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалтын дагуу хувь этгээдээс бусад этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины нь байнга оршин суугч бол голлох удирдлага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсын байнга оршин суугч гэж тооцно.

4. “Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч” гэж:

а/ тухайн Улс, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн язгч болон хуулийн этгээд, болон

б/ Франц Улсын хувьд голлох удирдлага нь Францад байрладаг бөгөөд Францын дотоодын хуулийн дагуу орлогынхоо хэсэгт татвар төлдөг хувь нийлүүлэгчид, хоршигсад, бусад гишүүн бүхий компани болон бүлэг этгээдийг хэлнэ.

5 дугаар зүйл. Төлөөлөгчийн газар

1. Энэхүү Конвенцид “Төлөөлөгчийн газар” гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь буюу хэсэгчлэн явуулдаг ажил хэргийн байрлалыг хэлнэ.

2. “Төлөөлөгчийн газар” гэдэгт тухайлбал:

а/ аж ахуйг удирдан явуулж буй газар.

б/ салбар байгууллага,

в/ албан байгууллага,

г/ үйлдвэр,

д/ цсх болон,

е/ уурхай, газрын тос буюу байгалийн хий ашиглах цооног, ил уурхай болон байгалийн бусад ашигт малтмал олборлож буй газар орно.

3. Зөвхөн 12 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилгын болон угсралтын ажлын талбайг төлөөлөгчийн газар гэж тооцно.

4. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад дурдсан “Төлөөлөгчийн газар” гэдэгт дараах үйл ажиллагаа үл хамаарна:

а/ аж ахуйн нэгж зөвхөн өөрийн бараа, эд агуурсыг хадгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор аливаа байгууламж ашиглах,

б/ аж ахуйн нэгж зөвхөн хадгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор бараа, эд агуурс ашиглах,

в/ аж ахуйн нэгж зөвхөн өөр бусад аж ахуйн нэгжээр боловсруулалт хийлгэх зорилгоор бараа, эд агуурс ашиглах,

г/ аж ахуйн нэгж өөртөө зориулан бараа, эд агуурс худалдан авах буюу мэдээлэл цуглуулах зориулалтаар байнгын байрлал ашиглах,

д/ аж ахуйн нэгж өөртөө зориулан бэлтгэх, туслах чанарын аливаа үйл ажиллагааг явуулах зорилгоор зөвхөн байнгын байрлал ашиглах.

е/ байнгын байрлалын нийт үйл ажиллагаа нь бэлтгэх буюу туслах чанарын хоршсон үйл ажиллагаанаас бүрдсэн тохиолдолд а -д дурдсан аливаа үйл ажиллагааны төрлүүднийг аливаа байдлаар нэгтгэн үйл ажиллагаа явуулах зорилгоор зөвхөн байнгын байрлал ашиглах.

5. Энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие даасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч Улсад Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгө болон нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ

(контракт) байгуулах эрх эдэлдэг бол уг аж ахуйн нэгжийг Хэтэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан улмаар энэ ажиллагааг явуулж буй байр нь дээрх заалтын дагуу төлөөлөгчийн газар болж чадахгүй тохиолдолд уг аж ахуйн газрыг төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

6. Хэтэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие даасан эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байгаа бол түүнийг Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

7. Хэтэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани нь Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршдог эсвэл Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа (төлөөлөгчийн газраар дамжуулан буюу бусад аргаар) явуулдаг компанийг хянадаг эсвэл хяналтад байдаг нь элгээр компанийг бие биеийнх нь төлөөлөгчийн газар гэж үзэх үндэс болохгүй.

6 дугаар зүйл. Үл хөдлөх хөрөнгөнөөс орох орлого

1. Үл хөдлөх хөрөнгөнөөс (түүний дотор хөдөө аж ахуй буюу ойн аж ахуйгаас) орлого олбол энэхүү хөрөнгө байрлаж буй Хэтэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

2. "Үл хөдлөх хөрөнгө" гэсэн нэр томъёог тухайн хөрөнгө байрлаж буй Хэтэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно. Аль ч тохиолдолд уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөд дагалдах өмч, хөдөө аж ахуй, ойн аж ахуйд ашиглагдаж буй мал амьтан, тонног төхөөрөмж, газар оролцсон өмчийн талаархи хуулийн заалтыг хэрэглэх эрх, ашигт малтмалын орд, рашаан ус болон байгалийн бусад баялгийн хөдөлгөөнт болон тогтмол төлбөрийн эрхийг багтаана. Харин хөлөг онгоц болон нисэх онгоцыг үл хөдлөх хөрөнгөд оруулахгүй.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь үл хөдлөх эд хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх буюу түр хөлсөөр өгөх, эсвэл бусад аль ч хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн 1 болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээнд ашигласан үл хөдлөх хөрөнгөнөөс олсон орлогод хамаарна.

5. Хувьцаа эзэмших, компанид оролцох, өмч эзэмших буюу хуулийн этгээдэж Хэтэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгийг шууд буюу шууд бусаар ашиглаад өөрөө буюу өөр хуулийн этгээдэд хөлслүүлэх бусад хэлбэрээр хэрэглэснэж эзэмшигч орлого олж байвал өмч байрладаг Улсад татвар ногдуулж болно.

7 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлээгүй тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дээр дурдсан үйл ажиллагааг төлөөлөгчийн газраар дамжуулан эрхэлбэл уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн төлөөлөгчийн газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн төлөөлөгчийн газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг төлөөлөгчийн газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харьцан адил, эсвэл төстэй үйл ажиллагаа, адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулж олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг төлөөлөгчийн газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс бүрт тооцно.

3. Төлөөлөгчийн газрын ашгийг тодорхойлоходоо аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад тус төлөөлөгчийн газраас өөрийн байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад улсад зарцуулсан аж ахуйн болон захиргааны зардлыг хасч тооцно.

4. Хэлэлцэн тохирогч Улсад аж ахуйн нэгж өөрийн салбарууддаа нийт орлогыг хуваарилдаг хэвшсэн аргаар төлөөлөгчийн газарт ногдох ашгийг хуваадаг бол тэр Улс энэ хэвшсэн аргаар татвар ногдох орлогыг тодорхойлоход 2 дугаар заалт саад болохгүй. Гэхдээ хэвшсэн аргаар орлогыг хуваарилсантай холбогдон гарах үр дүн нь энэ зүйлийн зарчмуудтай зөрчилдөхгүй байвал зохно.

5. Аж ахуйн нэгж нь төлөөлөгчийн газраар дамжуулан бараа, эд агуурсыг зөвхөн худалдан авдаг бол үүнийг үндэслэн уг төлөөлөгчийн газрыг ашиг олсонд тооцож үл болно.

6. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүлэн төлөөлөгчийн газарт хамаарах ашгийг тодорхойлох аргыг өөрчлөх баттай үндэслэлгүй бол тогтсон нэг аргыг жил бүр хэрэглэнэ.

7. Хэрэв аж ахуйн үйл ажиллагааны ашиг нь энэхүү Конвенцийн бусад зүйлд тусгайлан тодорхойлсон төрлийн орлогыг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

8 дугаар зүйл. Усан болон агаарын тээвэр

1. Олон улсын шугамд хөлөг онгоц болон нисэх онгоцоор тээвэр хийж олох ашигт зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн удирдлага оршдог Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулна.

2. Хэрэв усан замын тээврийн байгууллагын голлох удирдлага нь хөлөг онгоцон дээрээ байрладаг бол энэхүү хөлөг онгоцны харьяалах боомт оршдог Хэлэлцэн тохирогч Улсад, хэрэв харьяалах боомт үгүй бол

уг хөлөг онгоцны зээмшигч байнга оршин сууж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад түүнийг байрладаг гэж үзнэ.

3. Энэхүү зүйлийн 1 дүгээр заалт нь пул, хамтарсан үйлдвэр болон олон улсын тээврийн ашиглалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

9 дүгээр зүйл. Харьга аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а/ Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон хөрөнгөд шууд болов шууд бусаар оролцдог бол, эсвэл

б/ тодорхой этгээдүүд Хэлэлцэн тохирогч Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт буюу хөрөнгөд шууд буюу шууд бусаар оролцдог бол.

тэдгээр хоёр нэгжийн хооронд тогтсон худалдаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь биеэ даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцөлөөс ялгаатай байвал тухайн аж ахуйн нэгжид ногдох ёстой аливаа ашиг дээрх ялгаатай нөхцөлийн улмаас тооцогдоогүй байвал түүнийг уг аж ахуйн нэгжийн ашигт оруулан тооцож зохих журмын дагуу татвар ногдуулна.

2. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа нь бие даасан аж ахуйн нэгжийн хоорондын харилцааны нөхцөлтэй нийцэж бэйх тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжээс өөрийн Улсдаа татвар төлөх ёстой ашгийг эхэнд дурдсан Улс өөрийн ашиг гэж тооцон өөрийн аж ахуйн нэгжийн ашигт оруулан татвар ногдуулсан байвал нөгөө Улс зохицуулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэхүү ашгаас авах татварын хэмжээнд холбогдох зохицуулалт хийнэ. Ийм зохицуулалтыг хийхдээ энэхүү Конвенцийн бусад заалтуудыг харгалзан үзэх бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд шаардлагатай гэж үзвэл харилцан зөвлөлдөж болно.

10 дугаар зүйл. Дивиденд

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршигч этгээдэд төлж буй дивидендэд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ дивиденд төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсад тухайн дивидендэд өөрийн хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч дивиденд авагч этгээд нь түүний жинхэнэ зээмшигч бол ногдуулах татварын хэмжээ нь доор зааснаас хэтрэхгүй:

а/ дивиденд жинхэнэ зээмшигч нь компани бөгөөд тэрээр дивиденд төлж байгаа компанийн хөрөнгийн 10-аас доошгүй хувийг шууд буюу шууд бусаар зээмшиж байгаа бол дивидендийн нийт дүнгийн 5 хувиас.

6/ бусад бүх тохиолдолд дивидендийн нийт дүнгийн 15 хувиас.

Энэхүү заалт нь тухайн компаний дивиденд агуулсан орлогод ногдуулах татварт үл хамаарна.

3. Францын оршин суугч компаниас дивиденд авдаг Монголын байнга оршин суугч нь компанийн боломжоос үүдэн түүний дивидендээс урьдчилан төлбөр авч болно. Дивидендээс урьдчилан авсан төлбөрийн дүн нь энэхүү Конвенцийн дагуу дивиденд гэж тооцогдоно. Энэхүү төлбөрөөс 2 дугаар заалтын дагуу Францад татвар ногдуулна.

4. Энэхүү зүйлд тусгагдсан "Дивиденд" гэсэн нэр томъёонд хувьцааны ногдол ашиг "жоунссанс хувьцаа", "жоунссанс эрх", уурхайн хувьцааны ногдол ашиг, байгуулагчийн хувьцааны ногдол ашиг болон өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр оролцох эрхээ үүсэж орлого болон хуваарилалт хийж буй хуулийн этгээд байнга оршдог. Хэлэлцэн тохирогч Улсын хуулийн дагуу хувьцааны орлоготой адилтган татвар ногдуулдаг бусад орлогыг хэлнэ. "Дивиденд" гэсэн ойлголтод 16 дугаар зүйлд тусгагдсан орлогууд үл хамаарагдана.

5. Хэрэв дивидендийн эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог бөгөөд дивиденд төлөгч компани байрладаг нөгөө Улсад төлөөлөгчийн газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг товчлосон газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг дээрээ энэ төлөөлөгчийн газар буюу товчлосон газарт шууд хамааралтай бол 1, 2 ба 3 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал нөгөө Улс уг компанийн төлж буй дивидендэд татвар ногдуулж болохгүй. Гэхдээ уг компаниас нөгөө Улсад байнга оршин суугчид төлж байгаа дивиденд буюу дивиденд авах эрх нь нөгөө Улс дахь төлөөлөгчийн газар ба товчлосон газартай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин компанийн хуваарилагдаагүй ашигт төлөгдсөн дивиденд нь, хуваарилагдаагүй ашиг, бүхэлдээ буюу хэсэгчлэн нөгөө Улсад бий болсон ашиг, орлогоос бүрэлдэж байлаа ч гэсэн татвар ногдуулж болохгүй.

11 дүгээр зүйл. Хүү

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч, хэрэв уг хүүг хүлээн авагч нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ногдуулах татварын хэмжээ хүүгийн нийт дүнгийн 10 хувиас хэтэрч болохгүй.

3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан 1 дүгээр заалтад тодорхойлсноор Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч хүүг

хүлээн авч байгаа нөхцөлд тэр этгээд хүүг жинхэнэ эзэмшигч байх бөгөөд дор дурдсан нөхцөлүүдийн аль нэг нь биелэгдсэн байвал Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулахгүй:

а/ хүү хүлээн авагч нь Хэлэлцэн тохирогч Улсууд, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу тэдгээрийн хуулийн аливаа этгээд, түүний дотор тухайн Улсын Төв Банк, эсвэл уг хүүг эдгээр Улсууд, түүний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж буюу хуулийн этгээдийн аль нэг нь төлж байвал, буюу

б/ худалдаа, шинжлэх ухааны болон аж үйлдвэрийн багаж хэрэгсэл зээлээр худалдах, аж ахуйн нэгжээс нөгөө нэгжид үйлчилгээ үзүүлэх буюу барааг зээлээр худалдах, зээлийн байгууллагын зөвшөөрснөөр ямар нэгэн зээл олгохтой холбон хүүгийн төлбөрийг гүйцэтгэж байвал, буюу

в/ зээлдэгч байгууллагатай тохирсон аль нэг хэлбэрийн зээлийн хувьд хүүг төлж байвал.

4.Энэхүү зүйлд тусгагдаж буй “хүү” гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн орлогод оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого, ялангуяа улсын сангийн орлого, зээллэг бусад үнэт цааснаас орох орлого, мөн тэдгээрийн урамшууллын орлого орно.Харин төлбөр тооцоо хожимдуулсны торгууль нь энэхүү зүйлд дурдсан хүү гэж тооцогдохгүй.”Хүү” гэдэг нэр томъёо нь 10 дугаар зүйлийн заалтын дагуу дивиденд гэж үзсэн орлогын хэсгүүдийг үл хамаарна.

5.Хэрэв хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад төлөөлөгчийн газраараа дамжуулан үйл ажиллагаа явуулж, тэнд нь энэ хүү бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраас мэргэжлийн бие даасан үйлчилгээ эрхэлдэг бөгөөд хүү авах эрх нь дурдсан төлөөлөгчийн газар буюу товлосон газартай шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1, 2 ба 3 дугаар заалтыг мөрдлөг болгохгүй.Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6.Хүү төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бол, хүүг Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан, хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүү энэ төлөөлөгчийн газарт эсвэл товлосон газарт бий болж байгаа бол дээрх төлөөлөгчийн газар, эсвэл товлосон газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад хүүг бий болсон гэж үзнэ.

7.Хэрэв хүү төлөгч болон хүү авах эрхийг жинхэнэ эзэмшигчдийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн аль нэг гуравдагч этгээдийн хооронд тогтоосон онцлог харилцаанаас шалтгаалан төлж буй хүүгийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал, энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан эцэст дурдсан

хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүгийн төлбөрийн илүү гарсан зөрүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулж болно.

12 дугаар зүйл. Эрхийн шимтгэл, шан харамж

1. Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж буй эрхийн шимтгэл, шан харамжид Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа эрхийн шимтгэл, шан харамжид тухайн Улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг эрхийн шимтгэл, шан харамжийг хүлээн авагч этгээд нь түүний жинхэнэ эзэмшигч мөн бол ийнхүү ногдуулж байгаа татвар нь эрхийн шимтгэл, шан харамжийн нийт дүнгийн 5 хувиас хэтэрч болохгүй.

3.2 дугаар заалтыг үл харгалзан 1 дүгээр заалтад дурдсан эрхийн шимтгэл, шан харамж нь зохиогчийн эрх буюу түүнтэй адилтгах эрхийг ашиглах зөвшөөрлийн төлөө төлөх бүх төрлийн төлбөр байх бөгөөд түүнийг хүлээн авагч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бөгөөд түүний жинхэнэ эзэмшигч нь байвал зөвхөн тэр Улсад татвар ногдуулна.

4. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй "эрхийн шимтгэл, шан харамж" гэсэн нэр томъёонд, зохиогчийн эрх буюу түүнтэй адилтгах эрх, патент, аж үйлдвэрийн болон барааны тэмдэг, зураг төсөл, загвар, төлөвлөгөө, нууц томъёолол буюу арга ажиллагааг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, эсвэл аж үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны салбарт олсон арга туршлагатай (ноу-хау) холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөрийг хамааруулна.

5. Хэрэв эрхийн шимтгэл, шан харамж жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү орлого бий болж байгаа, эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан мэргэжлийн бие даасан хувийн үйлчилгээ хийдэг, түүнчлэн эрхийн шимтгэл, шан харамж авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн 1, 2 ба 3 дугаар заалтыг хэрэглэхгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

6. Эрхийн шимтгэл, шан харамж төлөгч нь Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч бол уг эрхийн шимтгэл, шан харамж Хэлэлцэн тохирогч Улсад бий болсон гэж үзнэ. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан эрхийн шимтгэл, шан харамж төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч Улсад төлөөлөгчийн газар эсвэл товлосон газраар дамжуулан эрхийн шимтгэл, шан харамж төлөх үүрэг хүлээж эрхийн шимтгэл, шан харамж нь тэрхүү төлөөлөгчийн газар эсвэл товлосон газарт бий болсон бол төлөөлөгчийн газар эсвэл товлосон

газрын оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад эрхийн шимтгэл, шан харамж бий болсон гэж үзнэ.

7. Эрхийн шимтгэл, шан харамж төлөгч болон авах эрхийг жинхэнэ эзэмшигчдийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн аль нэг гуравдагч этгээдийн хооронд тогтоосон онцлог харилцааны улмаас шалтгаалан төлж буй эрхийн шимтгэл, шан харамжийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрвэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан эцэст дурдсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүд энэхүү Конвенцийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

13 дугаар зүйл. Хөрөнгө борлуулсны орлого

1.а/ Энэхүү Конвенцийн 6 дугаар зүйлд хамаарах хөрөнгийг худалдаж борлуулснаас олсон орлогод уг хөрөнгө байрладаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

б/ Хөрөнгийг голлон эзэмшиж буй компани болов хуулийн этгээд нь Хэлэлцэн тохирогч Улсад байрлаж, уг хөрөнгийн хэсэг буюу бусад эрх нь нэг болон хэд хэдэн аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн шууд буюу дундын хөрөнгө нь болж байвал Хэлэлцэн тохирогч Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгө буюу түүнд хамаарах эрхийг борлуулснаас орох орлогод тэр Улсад татвар ногдуулна. Энэхүү заалтад уг аж ахуйн нэгж буюу хуулийн этгээдээс өөрийн гэсэн үйлдвэрлэл, худалдаа, хөдөө аж ахуйн буюу мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулахдаа ашиглаж буй үл хөдлөх хөрөнгө хамаарахгүй.

2. Хэлэлцэн тохирогч Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөдлөх эд хөрөнгийн зарим хэсэг буюу Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад мэргэжлийн бие даасан үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж байгаа товчлон газарт харьяалагдах хөдлөх эд хөрөнгийг худалдаж борлуулснаас орох орлого, мөн түүнчлэн ийм төлөөлөгчийн газар (дангаар буюу аж ахуйн нэгжийн хамт) буюу ийм товчлон газрыг худалдаж борлуулснаас орох орлогод нөгөө Улсад татвар ногдуулж болно.

3. Олон улсын шугамд ашиглагдаж буй хөлөг онгоц болон нисэх онгоц буюу эдгээр тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хамрагдах хөдлөх эд хөрөнгө худалдаж борлуулснаас олсон орлогод ийм тээврийн хэрэгслийн голлох удирдлага нь байрладаг зөвхөн тэр Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

4. Энэхүү зүйлийн 1, 2 ба 3 дугаар заалтад зааснаас бусад аливаа хөрөнгийг худалдан борлуулснаас орох орлогод зөвхөн уг хөрөнгийг худалдсан этгээдийн байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно.

14 дүгээр зүйл. Мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа

1. Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугчийн мэргэжлийн бие даасан үйлчилгээ үзүүлсэн, эсвэл бие даасан шинжтэй аливаа бусад үйл ажиллагаа эрхлэн олсон орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улсад татвар ногдуулж болно. Гэхдээ уг орлогод дараах тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад мөн татвар ногдуулж болно:

а/ хэрэв уг байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагаа явуулах үүднээс товлосон газар ашиглаж байвал, энэ тохиолдолд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад орлогын зөвхөн товлосон газарт хамаарагдах хэсэгт,

